



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 0767

Улаанбаатар хот

Г Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх  
эрсдэлийг үнэлэх заавар

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Осол, гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх зааврыг нэгдүгээр, Орон сууцан дахь үнэлгээний хуудсыг хоёрдугаар, Байшин хашаан дахь үнэлгээний хуудсыг гуравдугаар, Гэр хашаан дахь үнэлгээний хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тайлан мэдээг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт ирүүлж, сургалт, арга зүйгээр ханганд ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д, мэргэжлийн удирдлагаар ханганд ажиллахыг Гэмтэл, согог судлалын үндэсний төв /Э.Галбадрах/-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсвийн хүрээнд шийдвэрлэж, салбар дундын хамтын ажиллагааг ханганд ажиллахыг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга наарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141213518

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
сарын 09. өдрийн ~~11/2021~~ тушаалын  
нэгдүгээр хавсралт

## Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх заавар

### Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан мэдээгээр нийт өвчлөлийн аравны нэгийг осол гэмтлийн өвчлөл эзэлж, жил бүр 5.2 сая гаруй хүн осол гэмтлийн улмаас амь насаа алдаж байгаа бөгөөд 2021 онд осол гэмтлийн улмаас нас барах хүний тоо 8.4 саяд хүрсэн байна.

Монгол Улсад нийт осол гэмтлийн 86.6 хувийг санамсаргүй осол гэмтэл эзэлдэг ба 2021 оны эхний хагас жилийн байдлаар Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Хүлээн авах яаралтай, түргэн тусламжийн тасгаар тусламж, үйлчилгээ авсан нийт үйлчлүүлэгчдийн 45.9% /41794/ нь орон гэртээ осол, гэмтэлд өртөж эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байна. Сүүлийн 5 жилд нас барсан нийт тохиолдлын 17.1 хувь буюу 6 хүн тутмын 1 нь гэр орон, ахуйн нөхцөлд осол, гэмтэлд өртсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр III”-ийн үйл ажиллагааны чиглэл 1 дүгээр зорилтын 1.1.2-т заасан “Уналт, бэртэлтэд өртөж болзошгүй эрсдэлийг үнэлэх заавар, хяналтын хуудас боловсруулан батлуулах” зорилт тавьсан.

Дээрх үндэслэлүүдийн хүрээнд иргэдийн ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаарх эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдарч буй орчныхоо аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор тус зааврыг боловсруулсан болно.

### Хоёр. Зорилго

Гэр орон ахуйн орчинд осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, амьдралын буруу дадал зуршлыг засах, амьдарч буй орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх.

### Гурав. Нэр томьёоны тайлбар

3.1. “Осол гэмтэл” гэж гадны хүчин зүйлийн огцом буюу богино хугацааны үйлчлэл нөлөөллөөр хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаа, эрүүл мэндэд учрах хохирол буюу эмгэгшил юм. Гадны хүчин зүйл нь механик, туяа, халуун, хүйтэн, гэрэл, цахилгаан, даралт буюу физикийн, химийн гэх мэт олон төрлөөс бүрдэнэ. Осол гэмтлийг түүний үйлдсэн хэлбэрээр нь санамсаргүй болон санаатай тохиолдол гэж ангилдаг.

3.2. “Санамсаргүй осол гэмтэл” гэж зориудын агуулгагүйгээр буюу санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтлийн тохиолдлыг хэлнэ. Тухайлбал: зам тээврийн осол, өндөрөөс унах, гал түймэр, хордлого, живэх зэрэг тохиолдлыг;

3.3. “Аюулгүй байдал” гэж бусдын хор хөнөөллөөс (эсвэл бусад хүсээгүй албадлагын өөрчлөлтөөс) зайлсхийх, эсэргүүцэх чадвар;

3.4. “Ахуйн орчин” гэж амьдарч буй орчин нөхцөл буюу хүний өдөр тутмын хэрэгцээг хангасан байр, орон сууцыг;

3.5. “Гэрийн гадаах орчин” гэж хүмүүсийн эргэн тойронд орших байгаль ба нийгмийн бүхий л үзэгдэл, хэрэг явдал;

3.6. "Орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууцыг;

3.7. "Байшин хашаа" гэж нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байрыг;

3.8. "Гэр хашаа" гэж Монголын ард түмний уламжлалт сууц болох бүх төрлийн гэр, цаатны урцыг;

3.9. "Ариун цэврийн байгууламж" гэж нийтийн бохирын шугам, цооног, агааржуулагчтай болон энгийн, нүхэн жорлон, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламжийг;

3.10. "Эрсдэл" гэж хүний бие, ахуйн орчин, учрах хохирол, үүсч болзошгүй магадлалыг тооцож эрсдэлийг үнэлдэг бөгөөд эрсдэлийг дотор нь цахилгааны, биологийн, хүний үйлдлээс хамаарах зэрэг ангилна.

3.11. "Эрсдэлт бүлгийн хүн ам" гэж ахмад настан, тусгай хэрэгцээт хүмүүс, 0-5 насны хүүхэдтэй өрх, согтуурах, мансуурах донтох өвчтэй хүмүүс, архаг хууч өвчтэй өрх, өрх толгойлсон олон хүүхэдтэй өрх.

#### **Дөрөв. Ахуйн орчны аюулгүй байдлыг тогтоох, үнэлгээ өгөх аргачлал**

4.1. Ахуйн орчны аюулгүй байдлын үнэлгээг эрсдэлт бүлгийн хүн амд хийнэ.

4.2. Ахуйн орчны аюулгүй байдлыг үнэлэн, тогтооходоо энэхүү тушаалын хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралтыг ашиглана. Ахуйн орчин дахь осол, гэмтлийн эрсдэлийг үнэлэхдээ амьдарч буй сууцны төрлөөс нь хамаарч орон сууц, байшин хашаа, гэр хашаа гэж ангилах ба тус бүрт нь гадаад, дотоод орчин гэж 2 хуваана.

4.3. Орон сууцны айлын эрсдэлийг үнэлэхдээ 6 бүлэг, 60 асуултаас бүрдэх бөгөөд тийм, үгүй гэсэн хариултаар бөглөнө. ҮГҮЙ гэсэн тохиолдол бүр эрсдэлтэй гэж үнэлнэ.

4.4. Байшин хашаатай айлын эрсдэлийг үнэлэхдээ 7 бүлэг, 77 асуултаас бүрдэх бөгөөд тийм, үгүй гэсэн хариултаар бөглөнө. ҮГҮЙ гэсэн тохиолдол бүр эрсдэлтэй гэж үнэлнэ.

4.5. Гэр хашаатай айлын эрсдэлийг үнэлэхдээ 7 бүлэг, 62 асуултаас бүрдэх бөгөөд тийм, үгүй гэсэн хариултаар бөглөнө. ҮГҮЙ гэсэн тохиолдол бүр эрсдэлтэй гэж үнэлнэ.

4.6. Ахуйн орчны аюулгүй байдлын үнэлгээгээр илэрсэн эрсдэлийг ажлын 5 өдөрт арилгуулж, давтан үнэлгээг өвөл, зуны улиралд хийнэ.

#### **Тав. Ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх**

5.1. **Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагын үүрэг**

5.1.1 Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн ажилтанг чадавхжуулах сургалтанд жил бүр хамруулна.

5.1.2 Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн өрх бүрт эрүүл орчинг бүрдүүлэх, ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тохирсон зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллана. (7-14 хоногт эрсдэлийг арилгасан байх). Дахин үнэлгээ хийнэ.

5.1.3 Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэхэд туслах, зөвлөгөө өгөх бүлгийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

## **5.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үүрэг**

5.2.1. Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд Өрх, сум, тосгоны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангана.

5.2.2. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулж, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгаагаар хангах.

5.2.3. Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэхэд туслах бүлгийг байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын оролцоог хангаж, хамтран ажиллана.

## **5.3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн үүрэг**

5.3.1. Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангана.

5.3.2. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулж, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх, мэдээлэл, сургалт сурталчилгаагаар хангах

### **Зургаа. Үр дүнг тайлагнах**

6.1. Үнэлгээ тус бүрээр үнэлгээ хийгдсэн айлын тоо, илрүүлсэн зөрчлийн тоо, зөрчлийг зассан тоо гэсэн үзүүлэлтээр гаргана.

6.2. Өрх, сумын эрүүл мэндийн төв, Нийгмийн эрүүл мэндийн төв эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан өрхийн мэдээллийг аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газарт жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

6.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар ажлын үр дүнгийн тайлан мэдээг нэгтгэн жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ.

6.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь аймаг, нийслэлийн хэмжээнд Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан өрхийн мэдээлэл, хамрагдалтын хувь, зохион байгуулалт, үр дүн, дүгнэлт, зөвлөмж бүхий нэгтгэсэн тайланг Эрүүл мэндийн яаманд хагас жил болон жилийн эцэст ирүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11  
сарын 09. өдрийн 09:00 тушаалын  
хоёрдугаар хавсралт

ОРОН СУУЦ  
*/Ахуйн орчны аюулгүй байдлын үнэлгээний хуудас/*

1. Ерөнхий мэдээлэл		
	Хариулт	
1	Өрхийн тэргүүний нэр	
2	Үнэлгээ хийсэн огноо	
3	Оршин суугаа газар	
4	Боловсролын байдал	
5	Ажил эрхлэлт	
6	Утасны дугаар	
7	Танай өрхөд хэдэн хүн амьдардаг вэ?	Хүний тоо:
8	0-4 нас	Хүний тоо:
9	5-9	Хүний тоо:
10	10-14	Хүний тоо:
11	15-24	Хүний тоо:
12	25-55	Хүний тоо:
13	55-аас дээш	Хүний тоо:

## 2. Гэрийн гадаад орчны аюулгүй байдлын үнэлгээ

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
<b>Орц</b>			
2.1.	Орцны орох хэсгийн шат нь бариултай эсэх		
2.2.	Орц нь хангалттай гэрэлтүүлэгтэй эсэх		
2.3.	Орцны шал барзгар буюу гулсдаггүй гадаргуутай эсэх		
2.4.	Орцны хаалга босго, довжоогүй эсэх		
2.5.	Орцоор тусгай хэрэгцээт хүмүүс явах замтай эсэх		
<b>Шат</b>			
2.6.	Шат нь бүрэн бүтэн эсэх		
2.7.	Шат нь гэрэлтүүлэгтэй эсэх		
2.8.	Шат нь хальтардаггүй эсэх		
2.9.	Шатны нь бүрэн бүтэн хашлагатай эсэх		
2.10.	Шатны гишгүүр өгсөж, уруудахад аюулгүй эсэх		

## 3. Гэрийн дотоод орчны аюулгүй байдлын үнэлгээ

	Асуулт	Зочны өрөө	Унлагын өрөө	Коридор
		Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)
		Үгүй (-)	Үгүй (-)	Үгүй (-)
3.1	Гэрэлтүүлэг сайтай эсэх			
3.2	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх			
3.3	Цахилгаан залгуурын утас хана дагуу байрлуулсан эсэх			
3.4	Цахилгааны утас тавилгын араар байрлуулдаг эсэх			
3.5	Цахилгааны утас шалбархайгүй бүрэн бүтэн эсэх			
3.6	Хивс, хивсэнцэр нь гулсамтгай бус, зах, ирмэг нь нугаларч, эргээгүй эсэх			
3.7	Шал нь хальтардаггүй эсэх			
3.8	Тавилгуудын өнцөг нь зөөлөвчтэй эсэх /Ширээ, хаалга, шүүгээ г.м/			
3.9	Цонх найдвартай бэхлэгдсэн, түгжээтэй эсэх			
3.10	Цонхны ойр өндөр буйдан, тавилга байрлуулдаггүй эсэх			
3.11	Орны ойр шургуулга байрлуулдаг эсэх			
3.12	Орны ойролцоо ширээний гэрэл, гар чийдэн байгаа эсэх			

#### 4. Гал тогооны өрөө

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
4.1	Гал тогооны өрөө гэрэлтүүлэг сайтай эсэх		
4.2	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх		
4.3	Хурц үзүүртэй зүйлсийг хүүхэд гар хүрэхгүй газар байрлуулсан эсэх		
4.4	Хүнд, хөнгөн жинтэй сав суулгыг жингээр нь ангилаж, хүнд жинтэйг доор байрлуулсан эсэх		
4.5	Халуун зүйл жийрэглэх зориулалтын бээлий байгаа эсэх		
4.6	Хоолны ширээ бүтээлэггүй эсэх		
4.7	Гал тогооны тавилгуудын ирмэг нь зөөлөвчтэй эсэх		
4.8	Зуух, газ зэрэг нь хүүхэд хүрэхгүй далд газар байрладаг эсэх		
4.9	Халуун тогоо суурьтай эсэх		
4.10	Халуун сав, ус буцалгагч, халуун тогоог хүүхдийн гар хүрэхээргүй газар байрлуулж ажиллуулдаг эсэх		


#### 5. Угаалгын өрөө

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
5.1	Шал халтирдаггүй эсэх		
5.2	Угаалгын өрөө ханандаа бариултай эсэх		
5.3	Шүршүүр, усны цорго нь бүрэн бүтэн эсэх		
5.4	Шүргшүүр нь хүн хүрэхэд хялбар газарт байрласан эсэх		
5.5	Толь зохих өндөрт байрладаг эсэх		
5.6	Ванн, шүршүүрт хальтардаггүй шалавч хэрэглэдэг эсэх		
5.7	Ванны өрөөнд сандалтай эсэх		
5.8	Угаалгын бодис хүүхэд хүрэхгүй газарт байрласан эсэх		

#### 6. Бусад

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
6.1	Өндрөөс юм авах зориулалтын шаттай эсэх		
6.2	Утаяа мэдрэгч нь ажилладаг эсэх		
6.3	Гал унтраагч байгаа эсэх		
6.4	Хүүхэд хахахуйц жижиг тоглоом, зай, товч ил задгай байдаггүй эсэх		
6.5	Анхны тусламжийн хэрэгсэл байгаа эсэх		

Эрүүл мэндийн сайдын 2021 оны .....  
сарын 09.. өдрийн 12:00 тушаалын  
гуравдугаар хавсралт



## БАЙШИН ХАШАА

/Ахуйн орчны аюулгүй байдлын үнэлгээний хуудас/

Ерөнхий мэдээлэл		
	Хариулт	
1	Өрхийн тэргүүний нэр	
2	Үнэлгээ хийсэн огноо	
3	Оршин суугаа газар	
4	Боловсролын байдал	
5	Ажил эрхлэлт	
6	Утасны дугаар	
7	Танай өрхөд хэдэн хүн амьдардаг вэ?	Хүний тоо:
8	0-4 нас	Хүний тоо:
9	5-9	Хүний тоо:
10	10-14	Хүний тоо:
11	15-24	Хүний тоо:
12	25-55	Хүний тоо:
13	55-аас дээш	Хүний тоо:

1. Гэрийн гадаад орчны аюулгүй байдлын үнэлгээ			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
<b>Шат</b>			
1.1.	Шат нь бүрэн бүтэн эсэх		
1.2.	Шат нь гэрэлтүүлэгтэй эсэх		
1.3.	Шат нь хальтардаггүй эсэх		
1.4.	Шат нь бүрэн бүтэн хашлагатай эсэх		
1.5.	Шатны гишгүүр өгсөж, уруудахад аюулгүй эсэх		
<b>Хашаан дотор</b>			
1.6.	Хашаан дотор хангалттай гэрэлтүүлэгтэй эсэх		
1.7.	Хашааны газар нь хазгай бус, тэгш газарт байрладаг эсэх		
1.8.	Ахуйн нөхцөлд ашигладаг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цоожтой газар байрлуулдаг эсэх /Хүрэ, хөрөө, лоом, жоотуу г.м/		
1.9.	Тэсэрч дэлбэрэх шатамхай эд зүйлсийг тусад нь байрлуулдаг эсэх /газ, баллонтой хий, бензин г.м/		
1.10.	Гэрийн хог хаягдлаа ангилж, битүүмжилж, хаядаг эсэх		
1.11.	Муу усны нүх нь хүн унахаас сэргийлсэн таглаатай эсэх		
1.12.	Гэрэл, цахилгааны шийд нь цоожтой эсэх		
1.13.	Гэрийн тэжээвэр нохойтой бол бат бөх уяатай эсэх		
1.14.	Өвлийн улиралд хашаан доторх цасаа арилгадаг эсэх		
1.15.	Түлээ модыг зөв хураадаг эсэх		

2. Гэрийн дотоод орчны аюулгүй байдлын үнэлгээ			
Асуулт	Зочны өрөө	Унлагын өрөө	Коридор
	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)
	Үгүй (-)	Үгүй (-)	Үгүй (-)
2.1.	Гэрэлтүүлэг сайтай эсэх		
2.2.	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх		
2.3.	Өрөөнд явахад замд тээглэх зүйлгүй эсэх		
2.4.	Өндөр тавилгатай бол зориулалтын шат ашигладаг эсэх		
2.5.	Цахилгаан залгуурын утас хана дагуу байрлуулсан эсэх		
2.6.	Цахилгааны утас тавилгын араар байрлуулдаг эсэх		
2.7.	Цахилгааны утас шалбархайгүй бүрэн бүтэн эсэх		
2.8.	Цахилгааны нэг үүсгүүрт олон залгуур залгадаггүй эсэх		

2.9.	Хивс, хивсэнцэр нь гулсамтгай бус, зах, ирмэг нь нугларч, эргээгүй эсэх			
2.10.	Шал нь халитардаггүй эсэх			
2.11.	Тавилгуудын өнцөг нь зөөлөвчтэй эсэх			
2.12.	Цонх хамгаалалтын тортой эсэх			
2.13.	Цонх найдвартай бэхлэгдсэн, түгжээтэй эсэх			
2.14.	Хаалганы босгоны хэмжээ намхан эсэх			
2.15.	Орны ойр шургуулга байрлуулдаг эсэх			
2.16.	Орны ойролцоо ширээний гэрэл, гар чийдэн байгаа эсэх			

3. Гал тогооны өрөө			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
3.1	Гал тогооны өрөө гэрэлтүүлэг сайтай эсэх		
3.2	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх		
3.3	Хүрц үзүүртэй зүйлсийг хүүхэд гар хүрэхгүй газар байрлуулсан эсэх		
3.4	Хүнд, хөнгөн жинтэй сав суулгыг жингээр нь ангилаж, хүнд жинтэйг доор байрлуулсан эсэх		
3.5	Халуун зүйл жийрэглэх зориулалтын бээлий байгаа эсэх		
3.6	Хоолны ширээ бүтээлэггүй эсэх		
3.7	Гал тогооны тавилгуудын ирмэг нь зөөлөвчтэй эсэх		
3.8	Зуух, газ зэрэг нь хүүхэд хүрэхгүй далд газар байрлуулсан эсэх		
3.9	Халуун тогоо суурьтай эсэх		
3.10	Халуун сав, ус буцалгагч, халуун тогоог хүүхдийн гар хүрэхээргүй газар байрлуулж ажиллуулдаг эсэх		

4. Угаалгын өрөө			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
4.1	Шал халтирдаггүй эсэх		
4.2	Угаалгын өрөө ханандаа бариултай эсэх		
4.3	Шүршүүр, усны цорго нь бүрэн бүтэн эсэх		
4.4	Шүргшүүр нь хүн хүрэхэд хялбар газарт байрласан эсэх		
4.6	Ванн, шүршүүрт хальтардаггүй шалавч хэрэглэдэг эсэх		
4.7	Ванны өрөөнд сандалтай эсэх		
4.8	Угаалгын бодис хүүхэд хүрэхгүй газарт байрласан эсэх		

**5. Ариун цэврийн байгууламж (АЦБ)**

Асуулт		Тийм (+)	Үгүй (-)
5.1	Ариун цэврийн байгууламж (АЦБ) явахад тодорхой саад тогторгүй эсэх (овоолсон шороо, ухсан нүх, цас мөс г.м)		
5.2	Ариун цэврийн байгууламжийн (АЦБ) гэрэлтүүлэгтэй эсэх		
5.3	Гадна байрлах ариун цэврийн байгууламж (АЦБ)-ын шат, довжоо хөдөлгөөнгүй эсэх		
5.4	Ариун цэврийн байгууламжийн (АЦБ) цоожтой эсэх		
5.5	Хаалганы босго намхан эсэх		
5.6	Шал нь хальтардаггүй эсэх		
5.7	Ариун цэврийн суултуур найдвартай бэхлэгдэж, хэрэглэхэд тохиромжтой эсэх		
5.8	Ариун цэврийн суултуураас босоход туслах бариулыг суултуурын ойролцоо байрлуулсан эсэх		

**6. Бусад**

Асуулт		Тийм (+)	Үгүй (-)
6.1	Өндөрөөс юм авах зориулалтын шаттай эсэх		
6.2	Утаяа мэдрэгч нь ажилладаг эсэх		
6.4	Гал унтраагч байгаа эсэх		
6.5	Хүүхэд хахах эрсдэлтэй жижиг тоглоом, зай, товч ил задгай байдаггүй эсэх		
6.6	Анхны тусlamжийн хэрэгсэл байгаа эсэх		
6.7	Яаралтай тусlamжийн утасны дугааруудыг мэддэг эсэх		

---ооо---

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
сарын 09. едрийн тушаалын  
дөрөвдүгээр хавсралт



## ГЭР ХАШАА

/Ахуйн орчны аюулгүй байдлын үнэлгээний хуудас/

Ерөнхий мэдээлэл		Хариулт
1	Өрхийн тэргүүний нэр	
2	Үнэлгээ хийсэн огноо	
3	Оршин суугаа газар	
4	Боловсролын байдал	
5	Ажил эрхлэлт	
6	Утасны дугаар	
7	Танай өрхөд хэдэн хүн амьдардаг вэ?	Хүний тоо:
8	0-4 нас	Хүний тоо:
9	5-9	Хүний тоо:
10	10-14	Хүний тоо:
11	15-24	Хүний тоо:
12	25-55	Хүний тоо:
13	55-аас дээш	Хүний тоо:

1. Гэрийн гадаад орчны аюулгүй байдлын үнэлгээ			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
1.1	Гэрийн үүд гэрэлтүүлэгтэй эсэх		
1.2	Хашааны газар нь хазгай бус, тэгш газарт байрладаг эсэх		
1.3	Ахуйн нөхцөлд ашигладаг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цоожтой газар байрлуулдаг эсэх /Хүрз, хөрөө, алх, жоотуу г.м/		
1.4	Тэсэрч дэлбэрэх шатамхай эд зүйлсийг тусад нь байрлуулдаг эсэх /газ, баллонтой хий, бензин г.м/		
1.5	Гэрийн хог хаягдаа ангилж, битүүмжилж, хаядаг эсэх		
1.6	Гэрэл, цахилгааны шийт нь цоожтой эсэх		
1.7	Гэрийн тэжээвэр нохойтой бол бат бөх уяатай эсэх		
1.8	Өвлийн улиралд хашаан доторх цасаа арилгадаг эсэх		

2. Гэрийн дотоод орчны аюулгүй байдлын үнэлгээ			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
2.1	Гэрэлтүүлэг сайтай эсэх		
2.2	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх		
2.3	Гэрт явахад замд тээглэх зүйлгүй эсэх		
2.4	Цахилгаан залгуурын утас унь дагуу байрлуулсан эсэх		
2.5	Цахилгааны утас тавилгын араар байрлуулдаг эсэх		
2.6	Цахилгааны утас шалбархайгүй бүрэн бүтэн эсэх		
2.7	Цахилгааны нэг үүсгүүрт олон залгуур залгадаггүй эсэх		
2.8	Хивс, хивсэнцэр нь гулсамтгай бус, зах, ирмэг нь нугаларч, эргээгүй эсэх		
2.9	Шал нь хальтардаггүй эсэх		
2.10	Тавилгуудын өнцөг нь зөөлөвчтэй эсэх		
2.11	Хаалганы босгоны хэмжээ намхан эсэх		
2.12	Орны ойр шургуулга байрлуулдаг эсэх		

3. Хоол бэлтгэх хэсэг			
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
3.1	Гал тогооны өрөө гэрэлтүүлэг сайтай эсэх		
3.2	Гэрлийн унтраалга хүний гар хялбар хүрэх газарт байрласан эсэх		
3.3	Хүрц үзүүртэй зүйлсийг хүүхэд гар хүрэхгүй газар байрлуулсан эсэх		
	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)

3.4	Хүнд, хөнгөн жинтэй сав, суулгыг жингээр нь ангилж, хүнд жинтэйг доор байрлуулсан эсэх		
3.5	Халуун зүйл жийрэглэх зориулалтын бээлий байгаа эсэх		
3.6	Хоолны ширээ бүтээлэггүй эсэх		
3.7	Гал тогооны тавилгуудын ирмэг нь зөөлөвчтэй эсэх		
3.8	Зуух, газ зэрэг нь хүүхэд хүрэхгүй далд газар байрлуулсан эсэх		
3.9	Халуун тогоо суурьтай эсэх		
3.10	Халуун тогоо, ширмэн тогоо нь хүүхэд хүрэхгүй газар байрлуулсан эсэх		
3.11	Пийшин, зуух нь тусгаарлалтын хашлагатай эсэх		

#### 4. Угаалгын хэсэг

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
4.1	Шал халтирдаггүй эсэх		
4.2	Угаалгын бодис хүүхэд хүрэхгүй газарт байрласан эсэх		

#### 5. Ариун цэврийн байгууламж (АЦБ)

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
5.1	Ариун цэврийн байгууламж (АЦБ) явахад тодорхой саад тогторгүй эсэх (овоолсон шороо, ухсан нүх, цас мөс г.м.)		
5.2	Ариун цэврийн байгууламжийн (АЦБ) гэрэлтүүлэгтэй эсэх		
5.3	Гадна байрлах ариун цэврийн байгууламж (АЦБ)-ын шат, довжкоо хөдөлгөөнгүй эсэх		
5.4	Ариун цэврийн байгууламжийн (АЦБ) цоожтой эсэх		
5.5	Хаалганы босго намхан эсэх		
5.6	Шал нь хальтардаггүй эсэх		
5.7	Ариун цэврийн суултуур найдвартай бэхлэгдэж, хэрэглэхэд тохиромжтой эсэх		
5.8	Ариун цэврийн суултуураас босоход туслах бариулыг суултуурын ойролцоо байрлуулсан эсэх		

#### 6. Бусад

	Асуулт	Тийм (+)	Үгүй (-)
7.1	Өндрөөс юм авах зориулалтын шаттай эсэх		
7.2	Утаяа мэдрэгч нь ажилладаг эсэх		
7.4	Гал унтраагч байгаа эсэх		
7.5	Хүүхэд хахах эрсдэлтэй жижиг тоглоом, зай, товч ил задгай байдаггүй эсэх		
7.6	Анхны тусlamжийн хэрэгсэл байгаа эсэх		
7.7	Яаралтай тусlamжийн утасны дугааруудыг мэддэг эсэх		